

Хуралдсан газар:	Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, ХХБ-ны төв байрны 1 дүгээр давхарт танхимаар болон Investor.tdbm.mn цахим хаягаар хуралдав.
Хуралдсан өдөр:	2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр
Үргэлжилсэн хугацаа:	09:00-10:36
Хурлын дарга:	Рандолф Коппа
Хурлын нарийн бичгийн дарга:	Н.Нямсүрэн
Хурлын ирц:	09 цаг 05 минут эхэлсэн ирц 90.56% Санал хураалт эхлэх үеийн ирц 90.58%
Хуралд байлцсан:	Эрнст энд Янг ХХК аудитын байгууллага: Д.Мандахбаяр – Партнер А.Үжин – Ахлах менежер Худалдаа, хөгжлийн банк ХК: О.Банзрагч - Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч; А.Энхмэнд - Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч; Т.Батжаргал - Хуулийн газрын захирал; Т.Даваажав - Хөрөнгө зохицуулалтын газрын захирал; Г.Энхлхагва - Стратеги, хөгжил инновацийн газрын захирал.
Зохион байгуулах комисс:	Дарга: Н.Нямсүрэн – Төлөөлөн удирдах зөвлөлийн бичгийн дарга; Гишүүд: Ц.Ганбаяр - Хууль, эрх зүй хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч; Д.Энхтуяа - Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал; Т.Батжаргал - Хуулийн газрын захирал; Ш.Сэлэнгэ - Маркетингийн газрын захирал; Г.Энхлхагва - Стратеги, хөгжил, инновацын газрын захирал; Х.Ууганбаяр - Технологи, инновацын хэлтсийн захирал; Л.Сайнбаяр - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны гадаад харилцааны мэргэжилтэн; Х.Оюутсэцэн - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны хуульч.
Тооллогын комисс:	Дарга: Л.Одмаа – Дотоод аудитын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч; Гишүүд: Л.Анхбаяр – Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал; А.Болормаа – Комплайнсын хэлтсийн захирал; Б.Энхжаргал – Тусгай аудитын хэлтсийн ахлах аудитор; Н.Тэмүүлэн – Эрх зүйн бодлогын хэлтсийн хуульч; А.Энхжаргал – Ерөнхий аудитын хэлтсийн аудитор; Б.Саруулбуян – Ерөнхий аудитын хэлтсийн аудитор.



Танилцуулсан асуудал:

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан;

Танилцуулсан: О.Орхон - Гүйцэтгэх захирал;

2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр;

Танилцуулсан: Н.Нямсүрэн – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;

Хэлэлцсэн асуудал:

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;

Танилцуулсан: Н.Нямсүрэн – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;

2. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай.

Танилцуулсан: Д.Энхтуяа – Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал.

Хөтлөгч О.Баярсайхан:

Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулагч та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилж байгааг хүлээн авна уу.

Худалдаа хөгжлийн банкны 2023 оны амжилт, үр дүнгээ танилцуулахаар өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар та бүхэнтэйгээ энэхүү цаг мөчид танхимаар болон цахимаар уулзаж байна. Хурлаа эхлүүлэхээс өмнө та бүхэнд саналын хуудасны хамт тараагдсан хурлын дэгийн дагуу хурал зохион байгуулагдах тул та бүхэн Хурлын дэгтэй танилцана уу гэж хүсэж байна. Ингээд Хурлын ирцийн талаар мэдээлнэ үү хэмээн Тооллогын комиссыг индэрт урьж байна.

Тооллогын комиссын дарга Л.Одмаа:

Сайн байна уу. Та бүхэнд ирцийн мэдээллийг танилцуулъя. Саналын хуудсаар урьдчилан өгсөн санал 60.801%, Зайнаас буюу цахимаар оролцож байгаа 29.686%, Танхимаар оролцож байгаа 0.073% буюу нийт 90.56 хувийн ирцээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр эхэлж буйг мэдээлж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн мэдээллийг танилцуулж, хурал хүчин төгөлдөр болохыг баталгаажуулсан Тооллогын комисстоо баярлалаа. Ингээд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг албан ёсоор нээн үг хэлнэ үү гэж ХХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бөгөөд хурлын дарга ноён Коппа таныг тайзнаа урьж байна.

Хурлын дарга Рандолф Коппа: [АНГЛИ ХЭЛНЭЭС ОРЧУУЛАВ]

Хүндэт хувьцаа эзэмшигчид, хатагтай ноёдоо

Тооллогын комиссийн мэдээллэсэнээр өнөөдрийн хурлын ирц 90.56 хувьтай бүрдсэн тул Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр эхэлж буйг ийнхүү мэдэгдэж байна.

Хурлын албан ёсны үйл ажиллагаа эхлэхээс өмнө Төлөөлөн удирдах зөвлөл нэгж хувьцаанд 1,033 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн ба Монголбанкны зөвшөөрөл олгосны дагуу өнгөрсөн Баасан гарагт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв рүү шилжүүлсэн болохыг мэдэгдмээр байна.

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгаж, хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцохоор хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье. Та бүхэн мэдэж байгаачлан, банкны 2023 оны аудитлагдсан тайлан саяхан гарсан. 2023 он манай банкны хувьд болон Монгол улсын эдийн засгийн хувьд ч таатай сайхан жил байлаа. Бидний урьдчилан төсөөлсөн ёсоор, Монгол улсын экспортын голлох түүхий эдүүдийн үнэ ханш олон улсын зах зээл дээр 2023 оны турш сайн байсан ба энэ чиг хандлага одоо ч хэвээр үргэлжилж байна. Өнгөрсөн онд экспортын орлого сайн байсан нь нэг талаар төсвийн орлогод сайнаар нөлөөлж 2023 онд улсын төсөв ашигтай гарсан бол, нөгөө талаар төлбөрийн тэнцэл мөн ашигтай гарсан.

Ингэснээр ДНБ 7 хувийн өсөлтийг үзүүлсэн бол, инфляц төв банкны зорилтот түвшинд хүртэл буурсан. Монгол улсын гадаад валютын албан нөөц тасралтгүй нэмэгдсээр 2024 оны 3-р сарын байдлаар 5.2 тэрбум ам.доллар хүрсэнээр, түүхэн дээд түвшиндээ хүрээд байна. Үүний үр дүнд төгрөгийн ам.доллартай харьцах ханш өнгөрсөн онд болон энэ онд тогтвортой байна. Макро эдийн засагт гарсан энэ бүх эерэг үр дүн банкны сектор болон Худалдаа, хөгжлийн банкны гүйцэтгэлд сайнаар нөлөөллөө. Банк 2023 онд нийт актив, өөрийн хөрөнгө, олгосон зээл, харилцах хадгаламжийн хэмжээ зэрэг голлох бүхий л үзүүлэлтээр өндөр өсөлт үзүүлж чадсан. Банкны удирдлагын баг ажилтнууддаа талархал илэрхийлье. ГЗ танилцуулгадаа 2023 оны үр дүнгүүдийн талаар илүү дэлгэрэнгүй танилцуулна.

Банкны секторт нийт байгууллагын зээлийн хэмжээ, худалдааны санхүүжилт болон гадаад төлбөр тооцооны зах зээлд эзлэх байр суурийг авч үзвэл, банк 2023 онд байгууллагын болон олон улсын банкны зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа улам бэхжүүлж чадсан байна. Та бүхний мэдэж байгаачлан 2023 онд ХХБ нь АНУ-ын голлох банкуудын нэг болох Bank of New York Mellon –д төлбөр тооцооны дансаа нээсэн. Ингэснээр АНУ-ын банканд дансаа нээсэн Монгол улсын анхны арилжааны банк болсон бөгөөд цор ганц банк хэвээрээ байна. Энэхүү амжилт нь банкны өргөн цар хүрээтэй олон улсын банкны үйл ажиллагаа болон Комплайнсын бодлого, журам, практикаа тасралтгүй сайжруулсаны үр дүн билээ. Бид комплайнсын бодлого журам, практикаа улам сайжруулах талаар тасралтгүй хичээл зүтгэл гаргаж байгаагаа харуулаад зогсохгүй, Монгол улс олон улсын комплайнсын норм, стандартыг хангаж ажиллаж байгааг харуулж чадсан хэрэг явдал юм. Энэ чухал ажлын үр дүн гарч, 2024 оны 4-р сарын байдлаар Худалдаа, хөгжлийн банк Монгол улсын ам.долларын төлбөр тооцооны тэн хагасаас илүүг, худалдааны санхүүжилтийн 1/3-ийг хол давсан хэсгийг дангаараа гүйцэтгэж байна. Өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад томоохон ахиц гарсан байна.

Худалдаа, хөгжлийн банк нээлттэй хувьцаат компани болсоны хувьд компанийн засаглалаа тасралтгүй сайжруулахын зэрэгцээ тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаагаа улам эрчимжүүлж байна. Төрөл бүрийн ногоон зээл, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл зэрэг ногоон болон нийгмийн зээлүүдийг нэвтрүүлж, эдгээр бүтээгдэхүүнүүд харилцагчдын дунд өндөр эрэлттэй байна. Мөн Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ ESG буюу байгаль орчин, нийгэм, засаглалын хороог байгуулан ажиллаж байгааг дурдахад таатай байна. Та бүхний мэдэж байгаачлан 2023 оны 5-р сард хийсэн IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийг ногоон, тогтвортой санхүүжилтийг дэмжихэд ашиглах зориулалттай байсан. 2024 оны 1-р улирлын байдлаар IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийн 65 хувийг зориулалтын дагуу зарцуулаад байна.

Бид хувьцаа эзэмшигчид болон ажилтнууддаа хамгийн өндөр үнэ цэнийг бий болгохоор хичээн ажиллаж ирсэн бөгөөд энэхүү хүчин чармайлтаа цаашид ч үргэлжлүүлэн ажиллах болно. Худалдаа, хөгжлийн банканд өндөр итгэл хүлээлгэж байдаг, хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлье.

Хөтлөгч О.Баярсайхан:

ТУЗ-ийн дарга Коппа танд баярлалаа.

Өнөөдрийн хурлаар ТУЗ-ийн шийдвэрийн дагуу ХХБ ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах ба ХХБ ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх ТУЗ-ийн

гаргасан дүгнэлт болон ХХБ ХК-ийн ТУЗ-ийн зардлыг батлах тухай асуудлуудаар хэлэлцэн шийдвэрлэхээр байна. Ингээд хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулагчдаа зориулан ХХБ-ны үйл ажиллагаа болон санхүүгийн танилцуулгыг хийнэ үү хэмээн ХХБ ХК-ийн гүйцэтгэх захирал Ноён Орхон таныг индэрт урьж байна.

Гүйцэтгэх захирал О.Орхон:

За баярлалаа. Эрхэм ХХБ-ны хувьцаа эзэмшигчид Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Та бүхэнд Банкныхаа 2023 оны санхүү, үйл ажиллагааны тайланг танилцуулъя. Арилжааны ууган банкны хувьд бид банкны салбарт, цаашлаад Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах дэвшил бүхий анхдагч нь байх үндсэн зарчмаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид 2020 онд банкны алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг шинээр тодорхойлж, үүнтэй нийцсэн урт хугацааны тэргүүлэх стратегийн чиглэлүүдээ гаргасан. Үүнд: Харилцагч төвтэй банк, Олон улсын бөгөөд ногоон банк болох, Платформ банк болох гэсэн үндсэн 3 зорилгыг тавьж, эдгээр тэргүүлэх стратегиудтай уялдуулан бид дунд болон богино хугацааны бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, амжилттай хэрэгжүүлж байна. Бид харилцагч төвтэй банк болох стратегийн хүрээнд байгууллагын зах зээлийн тэргүүлээ хадгалж, иргэд болон жижиг, дунд бизнесийн зах зээлд хүчтэй тэлэлт хийх замаар активын зохистой бүтцийг цогцлоох зорилгыг тодорхойлсон.

Бид иргэдийн зах зээлээ амжилттай тэлж байгаа бөгөөд тухайлбал, бидний хэрэгжүүлж буй үндэсний хэмжээний томоохон аян, лоялти хөтөлбөрүүд үр дүнгээ өгсөөр байна. Та бүхний мэдэж байгаачлан бид “Бритто” лоялти экосистемийг амжилттай цогцлоож, цар хүрээгээ хурдацтай тэлж байгаа. Үүний нэг тод жишээ бол бид VISA картын зах зээлд эзлэх хувийг 2023 онд 29% болгож, 2 жилийн өмнөхтэй харьцуулахад 2 гаруй дахин нэмэгдүүлсэн.

“Хуримтлалтай Монгол” аяныг амжилттай үргэлжлүүлж, иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжихээс гадна өөрсдийн тогтвортой эх үүсвэрийг тасралтгүй нэмэгдүүлж байна. 2023 онд “Хуримтлалтай Монгол” аянд цоо шинэ харилцагчаар бүртгүүлсэн тоо өнгөрсөн жилүүдийнхээс нэмэгдэж 17,000-д хүрсэн. Бид эдгээр өсөлтийн боломжийг ашиглаж, иргэдийн зах зээлд үргэлжлүүлэн хүчтэй том тэлэлтийг хийж чадсан.

Та бүхэн танилцуулгаас харж байгаачлан байгууллагын харилцах, хадгаламжийн зах зээлд эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад 7.2 нэгж хувь буюу маш өндөр дүнгээр нэмэгдсэн. Энэ нь манай банкны байгууллагын хамтын ажиллагаа сайн байгааг илэрхийлж байна. Мөн жижиг, дунд бизнесийн зах зээлийн хувьд бид нийт системийн зээлийн 12.4%-ийг бүрдүүлж байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад 2.7 нэгж хувиар өссөн үзүүлэлт байна. Харин Иргэдийн зах зээлийн хувьд нийт зээлийн 10 орчим хувийг, нийт харилцах, хадгаламжийн 19%-ийг тус тус бүрдүүлээд байна. Бид жижиг дунд болон иргэдийн зах зээлд өсөлт гаргаж байгаа ч цаашдаа дахиад маш том боломж, орон зай бизнесийн боломжууд байгааг үүнээс харж болохоор байна. Миний түрүүн танилцуулсанчлан активын зохистой бүтцийг цогцлоох зорилгодоо алхам алхмаар ойртож байна.

2022 онд байгууллагын зах зээлийн нийт зээлд эзлэх хувь 69%, жижиг, дунд бизнес 12%, иргэдийн 19%-тай байсан бол 2023 онд 61.7%, 15.4%, 22.9% болж зорилтот харьцаа руугаа улам ойртсоор байна. Байгууллагын банкны сегментийн хувьд 2023 онд бид дараах шинэ шийдлүүд, дижитал боломжууд, бүтээгдэхүүн үйлчилгээнүүд харилцагчдаа санал болгож эхэлсэн. Томоохон байгууллага, жижиг, дунд бизнес болон иргэдийн харилцагч нартаа зориулж, тэдгээрийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй нэвтрүүлсээр байна.

Бид 2023 онд байгууллагын харилцагч нартаа дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр санал болголоо. Факторингийн үйлчилгээ 8.9 тэрбум төгрөгийн авлагыг санхүүжүүлсэн. Тээврийн санхүүжилтийн зээлийн эрхийн бүтээгдэхүүн гэж цоо шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж 1.7 тэрбум төгрөгийн ложистикийн зардал болон гаалийн төлбөрийг санхүүжүүлэв.

Байгууллагын зарлага гаргах эрхтэй Хадгаламжийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээр 1,6 тэрбумын эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн байна. Цахим овердрафт аккретитив болон баталгааны хүсэлтийг цахимжуулснаар харилцагчдынхаа цагийг хэмнэж цаасны хэрэгцээг амжилттай бууруулж чадсан байна. Жижиг дунд бизнесийн сегментэд хийсэн ажлуудын талаар дурьдахад андройд утсан дээрээ төлбөрийг шууд хүлээж авах боломжтой Софт Пос гэсэн төлбөрийн цоо шинэ шийдлийг зах зээлд анх нэвтрүүлж чадсан. Ингэснээр өнөөгийн байдлаар 1685 харилцагчид гар утсаа ашиглан пос хэлбэрээр 1,4 тэрбум төгрөгийн гүйлгээг хүлээж аваад байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээлийн бүтээгдэхүүн жижиг дунд бизнесийнхэндээ зориулж гаргасан ба 97 харилцагчид оны эцсийн байдлаар 3,7 тэрбумын зээлийг олгоод байна. Онлайн посын орлого барьцаалсан зээл шинээр бас нэвтрүүлснээр 93 харилцагчдад 2,6 тэрбум төгрөгийн зээл олгож, нийт хүсэлтийн 50%-ийг зайнаас шийдвэрлэж ажилласан байна. Гэрээ барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлж 21 харилцагчдад 10,4 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Зээлийн батлан даалттай бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүн, сүлжээ дэлгүүрийн авлага барьцаалсан зээлийн эрхийн бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүнүүдийг амжилттай нэвтрүүлээд байна.

Иргэдийн сегментийн хувьд цахимжуулалтын ажлыг маш эрчимтэй явуулж байгаа. Онлайн цалингийн зээлийн бүтээгдэхүүнийг аль банкаар цалингаа авдаг эсэхээс үл хамаарч авах боломжийг нэвтрүүлснээр нийт зээлийн 75%-ийг цахимаар шийдвэрлэж чадсан байна. Ингэснээр манай банкны нийт хэрэглээний зээлийн багцын 70%-ийг цалингийн зээл дангаараа бүрдүүлж байна. Энэ хугацаанд бусад банкаар цалин авдаг 8600 гаруй харилцагчдад зээл олгосон байна. VIP болон Premier харилцагчиддаа тохирсон Платинум багц бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлсэн. 2023 онд 119 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шинээр татан төвлөрүүлсэн. VIP харилцагчдийн тоо 71% болон Premier харилцагчдийн тоо маань 34% тус тус өссөн байна. Гадаад улсын иргэдийг харилцагчаар бүртгэж банкны үйлчилгээг зайнаас үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлснээр бараг 3 мянга орчим данс шинээр нээгдэж 49,2 тэрбум төгрөгийг эх үүсвэрийг 2023 онд татан төвлөрүүлсэн байна. Онлайн тэтгэвэрийн зээлийн бүтээгдэхүүнийг анхлан нэвтрүүллээ. Зээлийн багц 2 дахин нэмэгдэж 58 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт өсөлтийн 22%-ийг зайнаас шийдвэрлэсэн байна. Орон нутаг дахь харилцагч нарт зориулсан урьдчилгаа төлбөрийн батлан даалттай 3%-ийн ипотекийн зээлийг өнгөрсөн онд олгож эхэлсэн. Нийтдээ 300 гаруй харилцагчдын 28,7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Залуучууддаа зориулсан Эйнштейн залуусын багц бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн бөгөөд 2229 харилцагчдад 264 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

Стратегийн 2 дахь зорилго болох Олон улсын бөгөөд Ногоон банк болох гэсэн зорилгынхоо хүрээнд зах зээлд тэргүүлэгч байр сууриа улам бататгаж байна. Үүний тод жишээ бол гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа байна. Монгол Улсаас илгээсэн нийт гүйлгээний тоогоороо 39%, дүнгээрээ 31%-ийг манай банк гүйцэтгэсэн байна. Энэ нь жилийн өсөлтийн хувьд тооны хувьд 7.1 нэгж хувиар, дүнгийн хувьд 6.2% тус тус өссөн байна. Худалдааны санхүүжилтийн зах зээлд 33-аас 56% хүртэлх хувийг, Свифт гадаад хэлбэрт тооцооны хувьд 31-ээс 39%-ийг тус тус эзэлж үнэмлэхүй өсөлт үзүүлсэн байна. Худалдааны санхүүжилтийн үйл ажиллагаа танилцуулгын зүүн талд нь харагдаж байна.

Та бүгдийн сайн мэдэж байгаагаар өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид хөгжил дэвшилд хамтдаа уриан дор үйл ажиллагаагаа явуулж Монгол Улсынхаа томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж ирсэн бол одоо ирэх 30 жилийг бид Ногоон банк болох урт хугацааны стратегийн чиглэлийн дагуу ажиллаж уриагаа Тогтвортой хөгжилд хамтдаа болгон өөрчилсөн. Энэ ажлын хүрээнд 2030 он гэхэд 2 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний тогтвортой санхүүжилтийг Монгол Улсад оруулж ирж харилцагч нартаа олгох том зорилгыг урдаа тавиад ажиллаж байна. Үүнээс гадна Монголбанкны 2030 оны зорилт бол нийт банкны зээлийн 10%-ийг ногоон зээлээр бүрдүүлэх гэсэн зорилтуудыг тавин ажиллаж байгаа. Үүний хүрээнд манай банк том хөтөлбөр хэрэгжүүлж 2023 онд олгосон ногоон зээлийн багц маань 48,9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь банкны нийт зээлийн нэг орчим хувийг эзэлж байна. Гэхдээ банкны системийн ногоон зээлийн тоонд нийт олгосон зээлийн 20%-ийг бүрдүүлж байна. Ногоон зээлийн багцыг ашиглалтаар нь харвал 40% нь эрчим хүчний хэмнэлт, 25% нь карбон бага тээвэр, 23% нь тогтвортой ус хаягдлын хэрэглээ, 9% нь тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт ой болон эко аялал жуулчлал гэсэн ангиллаар олгоод байна.

Стратегийн 3 дахь зорилт Платформ банк болох хүрээнд бид дараах технологийн дэд бүтэц болон шийдлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд ажиллаж байна. Гол нь банкны суурь бүртгэлийн Temenos Transact гэж систем, мөн Дижитал банкны Temenos Infinity гэсэн энэ платформуудыг бид 2 дахь жилдээ дамнуулан нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ нь олон улсын зах зээлд дэлхийн тэргүүлэгч систем байгаа. Эдгээрийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан нэвтрүүлж дуусахаар төлөвлөөд ажиллаж байна. 2023 оны 6 дугаар сард банкны бүтээгдэхүүн үйлчилгээний API сервисүүдийг гуравдагч талд ашиглуулахтай холбоотой тэдгээрийг удирдах, зохион байгуулах, хянах, мэдээллийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх API Gateway management платформыг амжилттай нэвтрүүлж чадсан. Цахимжуулалтын ажлын үр дүн нийтдээ цалингийн зээлийн олголтын хувьд миний түрүүний дурдагдсанчлан 75,4%-ийг ямар ч хүний оролцоогүйгээр цахимаар түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан байна. Гүйлгээний хувьд цахим болон биет сувгийн гүйлгээний харьцаа 97:3 буюу зуун гүйлгээ тутмын 97% нь цахимаар хийсэн байна.

Онцлох үйл явдлуудыг товчхон дурдъя. Миний түрүүний ярьсан Бритто Эко системийг амжилттай цогцлоож, хуримтлалтай Монгол аяныг 4 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Танилцуулга дээр та бүхэн харж байгаа байх. 356 гаруй мянга гаруй харилцагчаас 409 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татаж чадсан байна. ХХБ-ны анхны цаасгүй цахим салбар нээгдсэн, 3 дугаар сард Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн хурдасгуур хөтөлбөрийг дэмжиж ажилласан байгаа.

Өнгөрсөн онд Монгол Улсад анх удаа худалдааны санхүүжилтийн форумыг зохион байгуулж 300 гаруй харилцагч нарт 10 гаруй олон улсын байгууллагууд оролцсон томоохон арга хэмжээ болсон. Энэ жил он гаргаад энэ арга хэмжээгээ 2 дахь удаагаа зохион байгуулсан байгаа. 5 сард Монгол Улсын Засгийн Газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас жил бүр тодруулдаг Топ 100 ААН-ийн 6-д бичигдсэн амжилттайгаар явж байгаад 6 сард олон нийтийн нээлттэй ХК болж 2528 хөрөнгө оруулагчдаас 105,5 тэрбум төгрөгийн худалдан авах захиалга ирснээр 126.4%-ийн биелэлттэйгээр амжилттай IPO хийж дуусгасан байна. Тогтвортой санхүүгийн 7 хоног олон улсын форумыг ТОС-ийн манлай банкны хувьд амжилттай зохион байгуулсан байгаа. Bank of China Хятадын хамгийн том арилжааны банктай стратегийн хамтын ажиллагааны санамж бичигт Улаанбаатар хотод гарын үсэг зурсан. Мөн сардаа Дэлхийн эдийн засгийн форумын Тяньжин хотод болдог зуны Давос хэмээх арга хэмжээнд оролцож Монгол Улсаас анх удаагаа Дэлхийн эдийн засгийн форумын албан ёсны түнш гэдэг статусыг олж гэрээ байгуулсан. БНХАУ-ын ICBC-ийн хөрөнгө оруулалттай Английн ICBC Standard гэж банк байдаг. Энэхүү банктай бүтэн жилийн хугацаанд ярилцсаны эцэст Глобал мастер ISDA гэдэг гэрээг байгуулж чадсан. Ингэснээр бид нар олон улсын зах зээл дээр своп болон деривативын арилжааг энэ банктай хийхээр болж байгаа. ISO стандартын харилцагчийн үйлчилгээний төгөлдөршлийн болон чанарын менежментийн тогтолцоо буюу хэрэглэгчийн сэтгэл ханамжийг үргэлж дээшлүүлэх гэсэн олон улсын стандартуудыг Монгол улсын банкны системд анх удаагаа манай банк нэвтрүүлсэн. 9 сард харилцагчийн үйлчилгээний нөхцөлийг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажилладаг Голомт банк, Төрийн банк болон Капитрон банк нартай хамтран харилцан АТМ төхөөрөмжөөс бэлэн мөнгө авах шимтгэлийн үйл ажиллагааг нэвтрүүлсэн. Өөрөөр хэлбэл манай банкны харилцагчид эдгээр банкаар алинаар нь ч үйлчлүүлсэн АТМ-ээр 100 төгрөгийн шимтгэл авхаар болсон байна. Үүний дүнд ХХБ-ны картыг Голомт банкны АТМ уншуулсан тоо 27 дахин, Төрийн банканд уншуулсан тоо 66%-аар, Капитрон банкаар уншуулсан тоо 16%-аар тус тус нэмэгдсэн байна.

9 сард Бүс ба зам санаачилга ногоон хөрөнгө оруулалтын GIR зарчмуудыг хэрэгжүүлэгч байгууллагаар Монгол улсаас шалгаран шагналыг (Award) хүртсэн байна. Тогтвортой хөгжлийн анхны бие даасан тайлангаа олон улсын GIR стандартын дагуу боловсруулж, олон нийтэд танилцуулсан. Олон улсад тэргүүлэгч технологи болох Genesys гэж системийг нэвтрүүлж, Genesys CX 2023 гэдэг шагналыг хүртэж АНУ-ын программ хангамжийн компаниас шагнал авсан Монголын анхны компани боллоо. Жил бүр шалгаруулдаг Тогтвортой санхүүжилтийн холбооноос Онцлох ТОС банкаар оны эцэст шалгарсан.

Хамгийн сүүлийн мэдээ бол өнгөрсөн оны 12 дугаар сард Монгол улс FATF-ын саарал жагсаалтад орсноос хойш бүтэн 5 жилийн турш бэлдэж, үйл ажиллагаагаа олон улсын стандарт, комплайнсын

стандартуудад нийцүүлж ажилласны үр дүнд АНУ-ын Bank of New York Mellon банканд ам.долларын ностра дансаа нээж чадсан цорын ганц арилжааны банк болж чадсан. Ингэснээр бид он гараад маш эрчимтэй маркетингийн ажиллагаа явуулсан ба миний түрүүний ярьсан гадаад төлбөр тооцооны market share 39%-аас одоо бүүр 40 гараад 50 хувь руу нэлээн дөхөж яваа үзүүлэлттэй байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 онд маш олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Зарим хэсгээс нь ТУЗ-ийн дарга Коппа дурдсан. Та бүгдэд тараасан танилцуулга дотор энэ талаар бас дэлгэрэнгүй орсон. Би ганц слайдад багтаан та бүхэнд багцалж танилцуулж байна. Ажилтнуудынхаа цалинг жил бүр 25%-аар өсгөж, 4 жилийн дотор 100% өсгөнө гэсэн амлалтыг олон нийтэд нээлттэй гаргасан. Энэ жил бид бас энэ амлалтынхаа дагуу 25 хүртэлх хувиар цалингаа нэмсэн байгаа.

Бага насны хүүхдүүд, оюутан сурагчдад хүрдэг манай Хязгааргүй мөрөөдөл аян маань үргэлжлээд явж байна. Хүн бүр байгаль хамгаалагч, Олон улсын Save the Planet контенттой хамтарч ажилласан байна. Монголчуудын түүх, өв соёлоо эрхэмлэн дээдлэгч залуу үедээ өвлүүлэх тал дээр бид нар түгээх ажил, Mongolian Open innovation co-creation for SDG гээд Жайка олон улсын байгууллагатай хамтран дэмжиж ажилласан байна. Эмч эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэж 6%-ийн зээлийг ямар нэгэн очер дугааргүйгээр үргэлжлүүлэн олголтыг хийж, дэмжиж ажилласан байна. World space week гээд хүүхэд залууст зориулсан шинжлэх ухааны цорын ганц эвент арга хэмжээ байдаг. Энийг ивээн тэтгэж 30 гаруй мянган хүүхдийг шинжлэх ухаанд сонирхолтой болгохын төлөө ажилласан байна. Үүнээс гадна бид өнгөрсөн жил зохион байгуулагдсан Монголын эдийн засгийн форум, Australian chamber, JICA business match, Next solution networking event, Япон Монголын бизнес нэтворкинг, Invest Khovd 2023, Блүүмберг телевизийн 2023 оны Awards зэрэг томоохон арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцож, зохион байгуулж, өөрсдийн болон гол нь харилцагчдынхаа дуу хоолойг идэвхтэй оруулсан билээ.

Бид ноднин IPO хийж байхад нийт татан төвлөрүүлсэн 83,5 тэрбум төгрөгийг стратегийнхаа гол урт хугацааны зорилт болох ногоон, тогтвортой санхүүжилтэд олгоно гэж зорьсон байгаа. Энийгээ олгохдоо стратегийнхаа сегментчиллийн дагуу байгууллагын сегментэд 50%, жижиг дунд бизнест 20%, иргэдэд 30%-аар олгохоор төлөвлөсний дагуу санхүүжилт хийгдэж байна.

Миний танилцуулгын сүүлийн хэсэг болох санхүүгийн гүйцэтгэлийг та бүхэндээ товч танилцуулъя. Үүний дараа Эрнст энд Янг ХХК-ийн аудиталсан тайлан танилцуулагдах учраас товч хэдэн үзүүлэлтүүдийг тавья. Зээлийн багцын хувьд болбол 16%-ийн өсөлттэй ажилласан байна. Харилцагчдын харилцах хадгаламжийн хувьд 46,4%-ийн өсөлттэй гарсан. Энэ нь бид нарын төсөөлж байсан хэмжээнээс харилцах харилцагчдын татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт даруй 2 дахин өндөр гаргасан байгаа. Зээлийн хувьд төдийлөн өндөр хэмжээний эрэлттэй байсангүй.

16%-ийн өсөлт гэдэг бол системийнхээ өсөлттэй харьцуулахад манай банкны хувьд харьцангуй арай доогуур өсөлт байгаа. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу 7 төлбөр төлөгчийн 55.2 тэрбум төгрөгийн активыг эрсдэлийн сангаас хаасан.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ оны эцсийн байдлаар 16.6%-тай болж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа бараг 50%-тай гарсан. Үүний гол үр дүн бол миний түрүүний хэлсэн татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт, зээл олголтын өсөлтөөс хамаагүй өндөр байсантай холбоотой.

Татварын дараах ашиг өнгөрсөн онтой харьцуулхад 22.2%-иар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Нийт актив маань өссөн үзүүлэлттэй гарсан ба активын өгөөж 2% байснаас 1,2% болж буурсан. Өөрийн хөрөнгө 1,4 их наяд болж 19.6%-аар өссөнөөр өөрийн хөрөнгийн өгөөж 10.7%-тай 2023 онд гарсан байна. Банкны секторт эзлэх хувь нийт актив, нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн хувьд 20 гаран хувьтай буюу бүх үзүүлэлтээрээ банкны системдээ 2-т явж байгаа. Зээлийн хувьд түрүүний хэлсэнчлэн арай бага 19%-тай, харин харилцагчдын харилцах, хадгаламжийн хувьд хамгийн өндөр буюу 23.2%-ийг эзэлж байна. Өнгөрсөн жилд зах зээлийнхээ хувийг 2.8 нэгж хувиар өсгөж чадсан үзүүлэлттэй ажилласан байна. Анхаарал тавьсан та бүхэндээ баярлалаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Н.Нямсүрэн:

Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэнд ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулья. ХХБ нь сүүлийн 3 жилийн хугацаанд тасралтгүй ногдол ашиг хуваарилсан ба нэгж хувьцаанд 1248-аас 7280 төгрөг хүртэл буюу нийт үнийн дүнгээр 10 тэрбумаас 60 тэрбум хүртэл төгрөгийн ногдол ашиг хуваарилжээ. Банкны 2023 оны цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж энгийн хувьцаанд олгох ногдол ашгийг хуваарилахаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв рүү шилжүүлсэнийг та бүхэн өнгөрсөн 5 дахь өдөр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдсэн гэдэгт итгэлтэй байна. Банкны ТУЗ нь 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, 2023 оны санхүүгийн аудитлагдсан тайлан гарсны дараагаар буюу санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсны дараах цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байсан. Ингээд 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр ХХБ нь “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-иас 2023 оны санхүүгийн аудитлагдсан тайланг хүлээн авсан. Үүний дараагаар ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн дагуу банкны хувьцаа эзэмшигчдэдээ эрхийг нь эдлүүлж банкны ашигт ажиллагаанаас үр ашиг хүртээх нь зүйтэй гэж үзсэн учраас 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 25 тоот тогтоолоороо ХХБ-ны 2023 оны цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж энгийн хувьцаанд 1,033 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдрөөр, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд олгох ажиллагааг банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хангалттай уялдуулан зохицуулагч байгууллага буюу Монголбанкнаас зөвшөөрөл ирсний дараа ажлын 5 хоногийн дотор хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Орхонд үүрэг болгосон. 2024 оны 4 дүгээр сарын 23-нд бид Монголбанкнаас зөвшөөрлөө авсан ба ХК болсонтой холбоотойгоор энэ жилээс бид Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг хувьцаа эзэмшигчид хуваарилах ёстой учраас Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулж, 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр ногдол ашгийг тус төв рүү шилжүүлсэн. 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 25 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 1,033 төгрөг, нийтдээ 52,3 тэрбум төгрөгийн ногдол ашиг буюу IPO гаргах үед нийт хувьцаа эзэмшигчдээ танилцуулж байсан цэвэр ашгийн 30%-д ногдол ашиг хуваарилна гэсэн төлөвлөгөөндөө хүрсэн. Ногдол ашгийн тухай танилцуулга дуусаж байна.

Ингээд эхний хэлэлцүүлэх асуудал буюу “ХХБ ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” асуудлыг танилцуулья. Компанийн тухай хуулийн зохицуулалтын дагуу ТУЗ нь компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах үүрэгтэй байдаг. Үүний дагуу ТУЗ нь банкнаас тавьсан 2023 онд банкны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд үндэслэн Компанийн тухай хууль, Банкны зохистой засаглалын зарчим, Компанийн засаглалын кодекс, ХХБ-ны дүрмийн хүрээнд дараах дүгнэлтийг гаргасан. Дүгнэлтийг танилцуулахын өмнө товч мэдээлэл өгөхөд ТУЗ-ийн гишүүд ХХБ-ны 2023 оны бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг хараат бус байдлаар үнэлж, тухайн үнэлгээн дээр үндэслэн дүгнэлтийг гаргасан.

Би ТУЗ-ийн 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 33 тоот “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай” тогтоолыг уншиж танилцуулья.

“Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт:

Энэхүү дүгнэлтийг Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “ХХБ” гэх)-ийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны зохистой засаглалын зарчим, Компанийн засаглалын кодекс болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаар хэлэлцэн гаргаж байна.

ХХБ төдийгүй банкны сектор нь томоохон өөрчлөлт, шинэчлэлтийг хийж, системийн нөлөө бүхий банкууд Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа олон нийтэд арилжаалдаг нээлттэй хувьцаат компани болж, банкны секторын нийт актив жилийн 24.2 хувийн өсөлт үзүүлж, 57.0 их наяд төгрөгт хүрч, цар тахлын нөлөө буурч, эдийн засаг сэргэж, банкны ашигт ажиллагаа сайжирсан зэрэг амжилт, бүтээлээр 2023 оныг үдэж, Монгол Улсад банкны систем үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтаж байна. Хувьцаат компани болсонтой холбогдуулан олон талт, ур чадвартай боловсон хүчнээр ТУЗ-ийн гишүүдийн тоо нэмэгдэж, банкны бизнесийг дэмжих, өргөжүүлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, дотоодын төдийгүй олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зэрэг өргөн хүрээний чиглэл, зөвлөмжийг өгөх бололцоог бүрдүүлсэн. ХХБ-ны ТУЗ нь 2023 онд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Банкны зохистой засаглалын зарчмууд болон ХХБ-ны дүрмийг тус тус мөрдлөг болгож, ТУЗ, түүний дэргэдэх хороодын тогтоол, шийдвэр, зөвлөмж зэргээр ХХБ-ны үйл ажиллагааг удирдан чиглүүлж, оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлэхээр хичээн ажиллаа. Түүнчлэн, 2023 оны банкны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг ХХБ-ны урт болон дунд хугацааны стратегийн хэрэгжилт, тухайн жилийн батлагдсан санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлө Суурь гөөний биелэлтийг ТУЗ-ийн гишүүдийн хараат бус байдлаар гаргасан үнэлгээний үр дүнд суурилан гаргасан болно.

ХХБ-ны Гүйцэтгэх удирдлагаас эхлэн нийт ажилтнууд нь тус банкны (i) Харилцагч төвтэй банк болох, (ii) Олон улсын банк болох, (iii) Платформ банк болох урт хугацааны зорилгуудын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулж, нийт активыг 12.1 их наяд, хуримтлагдсан ашгийг 151.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн амжилттай ажилласан байна.

Урт хугацааны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө

Харилцагч төвтэй банк болох. Үйлчилгээний төгөлдөршлийн олон улсын стандартууд болох ISO235952 болон ISO9001:2015-г Монгол Улсад анхлан нэвтрүүлж, харилцагчдын туршлага болон сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд төвлөрч, "Бритто Лоялти", "Хуримтлалтай Монгол", "Genesys" дуудлагын төвийн системийн шийдэл болон бусад банкуудтай хамтран АТМ-н шимтгэлээ бууруулах зэргээр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, харилцагч нартаа илүү ойртсон. Бүх сегментийн харилцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн Software POS, Онлайн цалин, тэтгэвэр, ПОС барьцаалсан зээл, Факторингийн үйлчилгээ гэм мэт олон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй санал болгож байна.

Олон улсын банк болох. Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын саарал жагсаалтаас гарснаас хойш Америкийн Нэгдсэн Улсын BNY Mellon банканд ам.долларын ностро данс нээсэн анхны банк болж, харилцагчид гадаад мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг илүү хялбар, бодит цагийн горимоор, шимтгэл багатайгаар хүргэх боломжийг олгосон. Түүнчлэн, Монгол Улсаас анх удаа ХХБ Дэлхийн эдийн засгийн форумтай албан ёсны түнш болж, Mitsui & Co., Ltd. компанитай хамтран Зэсийн Экспортыг дэмжих санхүүжилтийг амжилттай олгож, Bank of China-тай стратегийн түвшинд хамтран ажиллах санамж бичиг үзэглэсэн.

Платформ банк болох. API gateway удирдлагын платформыг амжилттай нэвтрүүлж, Open API үйлчилгээг бүрэн ашиглахад бэлэн болгосон. Банкны суурь систем болох Temenos Transact 24, дижитал банкны платформ Temenos Infinity-г нэвтрүүлэх ажлыг амжилттай үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Цалин, тэтгэврийн болон ПОС барьцаалсан зээлийг цахимаар авах боломжтой болгож, цалингийн зээлийн 75.4%, тэтгэврийн 22.4%, ПОС барьцаалсан зээлийн 50.3% нь цахимаар шийдэгдэв. Цаасгүй лайт салбараа шинээр нээж, харилцагчдад цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ санал болгож байна.

Санхүүгийн үзүүлэлт. ХХБ нь 2023 онд хүүгийн орлогыг 13.4 хувиар, шимтгэл хураамжийн орлого 21.2 хувиар өсгөж, чанаргүй зээлийг 15.6 тэрбум төгрөгөөр тус тус бууруулснаар 151.2 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан ба ХХБ-ны өөрийн хөрөнгийн хэмжээ 19.6 хувиар өсөж, 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Түүнчлэн, 2023 оны эцсийн байдлаар ХХБ нь Банкны секторын нийт активын 21.3 хувь, нийт зээлийн 19.2 хувь, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 21.1 хувь, нийт ашгийн

11.9 хувийг тус тус бүрдүүлж Монгол Улсад төдийгүй олон улсын нэр хүнд бүхий байгууллагын байр сууриа хадгалж, өргөжүүлэн ажилласан байна.

Нийгмийн хариуцлага. Монгол Улсынхаа хөгжил дэвшилд хөрөнгө оруулалт хийхийг зорьж, олон төсөл хөтөлбөрүүдийг зохион байгуулж, ивээн тэтгэгчээр ажилласан төдийгүй санхүүгийн боловсролыг түгээх, байгаль орчин, нийгэм засаглалыг сайжруулах аяны хүрээнд Save The Planet, эмч эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудалд тус дэм болох зорилготой орон сууцны зээлийг шийдвэрлэх, Худалдааны санхүүжилтийн форум зохион байгуулах, ажилтнуудынхаа цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүлсэн зэрэг олон үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаа. Мөн хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг ногоон болон нийгмийн зээлийн ангиллуудад уялдуулан санхүүжүүлж байна.

Түүнчлэн, ХХБ нь “БҮС ба ЗАМ санаачилга ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд (GIP)”-аас шалгаруулдаг “GIP AWARDS 2023”-н “Шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээ” үзүүлэгч байгууллага, “Тогтвортой санхүүжилтийн холбоо”-ны Онцлох ToC банк, “World Economic Magazine” сэтгүүлийн “Best Bank for Remittances Mongolia 2023”-аар тус тус шалгарсан байна.

Эх үүсвэрийг төрөлжүүлэхэд анхаарч ажиллах шаардлага үүсэж байгаа хэдий ч чанаргүй зээл, Монгол Улсын уул уурхайн салбарын хамаарал болон олон улсын зах зээлүүдэд суурь хүү өсөж байгаа нь эх үүсвэрийн өртгийг нэмэгдүүлж байгаа тул энэхүү сорилтуудыг давж ажиллах зорилтыг тавьж ажиллах арга хэмжээг авах нь зохистой байна.

ТУЗ-ийн зүгээс банкны Гүйцэтгэх удирдлага болон нийт ажилтнуудаа 2023 оны гүйцэтгэл, амжилтдаа суурилан батлагдсан төсөв төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанарыг сайжруулж, зах зээлд эзлэх байр сууриа тэлэх, харилцагч, хамтрагч, түншүүддээ зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэмэгдүүлэх, хялбаршуулах, хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээнүүдийг авч ажиллах чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэн одоогийн байр сууриа нэмэгдүүлэн 2024 ондоо өндөр гүйцэтгэлтэй ажиллана гэдэгт итгэлтэй байна. ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд өөрсдийн мэдлэг чадвараа банкныхаа хөгжил дэвшилд нэмэрлэн, хамтран ажиллах бөгөөд 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн Худалдаа, хөгжлийн банкныг 2023 онд “**хангалттай сайн**” ажилласан гэж дүгнэж байна.” Та бүхэнд Тузийн дүгнэлтийг танилцууллаа.

СУХГ-ын захирал Д.Энхтуяа:

Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын тавьсан танилцуулгатай холбогдуулаад нэмэлт тодруулга хэлэхэд банк 2023 оны санхүүгийн үйл ажиллагаагаа Эрнст энд Янг компаниар баталгаажуулж, олон улсын санхүүгийн тайлагналын стандартад нийцүүлэн 2024 оны 3 сарын 29-ний ТУЗ-ийн хуралд хараат бус аудиторын компани маань танилцуулан аудитын тайлангаа хүлээж авсан байгаа. Энэхүү аудитын тайланд үндэслэн саяны санхүүгийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, ТУЗ-өөс банкныг үнэлснийгээ сая танилцуулсныг нэмэлтээр би тодруулж хэлье гэж бодож байна. Бид бас Банкны тухай хуулиар санхүүгийн тайлангаа дараа жилийн 1 дүгээр улиралдаа багтаан аудиторoor баталгаажуулна. Мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд энэ танилцуулах материалыг оруулсан байгаа учраас та бүхэнд танилцуулагдсан, тараагдсан байгаа материал дотор манай санхүүгийн тайлан дээрээс нь банкны вэб сайтуудад санхүүгийн тайлан байгаа учраас танилцсан гэж үзсэн байгаа юм. Миний танилцуулах асуудал бол ХХБ ХК-ийн ТУЗ-ийн зардлыг батлуулах тухай танилцуулга байна. Монгол Улсын компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, ХХБ ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалтад заасны дагуу ХЭХ-аар хэлэлцэн шийдвэрлэх асуудалд энэхүү асуудал маань хамаарагдаж байна. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд ТУЗ-ийн цалин урамшууллийг тухайн компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол гэсэн заалттай байгаа. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрмийн 7.2.11-д бол ХХБ-ны ТУЗ-ийн зардал буюу түүнд хамаарагдах зардлыг батлуулахаар ХЭХ-д танилцуулдаг байгаа. ТУЗ-ийн 2024-өөс 2025 оны буюу энэ жилээс дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрийг хүртэлх хугацааны зардлын төсвийг 5 тэрбум төгрөгөөр батлуулах саналыг танилцуулж байна. Уг зардлуудад дараах зардлууд орж байна. ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин хөлс,

түүнтэй холбогдох татвар, шимтгэл, гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авалтын зардал, мэргэжлийн бусад үйлчилгээ, бусад гэсэн ийм зардлын хүрээнд 5 тэрбум төгрөгийг батлуулахаар санал оруулж байна. Миний хувьд танилцуулах асуудал боллоо. Баярлалаа.

Хөтлөгч О.Баярсайхан:

Хэлэлцэн батлуулах асуудалтай холбоотой танилцуулгыг хийсэн захирлууддаа баярлалаа. Асуулт, хариултын хэсэг үүгээр эхэлж байгааг та бүхэнд дуулгахад таатай байна. Та бүхнийг хурлын дэгтэй танилцсан гэдэгт итгэлтэй байна. Танилцуулсан асуудалтай холбогдолгүй асуултад бидний зүгээс хариулт өгөх боломжгүй тул хэрэв танд тодруулах зүйл байвал хурлын дараа бидэнд цахим шуудан болон бичгээр хандан тайлбар авах боломжтой гэдгийг та бүхэнд хэлмээр байна. Асуулт асуух, хариулт авах хүсэлтэй байгаа эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэн тайзны голд байрлуулсан микрофон дээр очин асуултаа асуухыг хүсэж байна.

Танхимаар болон цахимаар оролцож байгаа хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байхгүй байгаа тул хурлын хөтөлбөрийн дагуу асуулт хариултын хэсэг үүгээр өндөрлөж байна. ХЭХ-ын ээлжит хурлаас гарах тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

**ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.7 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.9 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банкны 2023 оны жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралтын дагуу баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

**ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын

шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024-2025 оны буюу дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрийг хүртэлх зардлын төсвийг 5,000,000,000.00 (таван тэрбум) төгрөгөөр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

Ийнхүү ХЭХ-аар хэлэлцэх асуудлууд болон тогтоолын төслүүдийг уншиж танилцуулсан тул санал хураалтын хэсэгтээ орьё. Та бүхэнд одоо санал хураалттай холбоотой зөвлөгөөг видеоогоор хүргүүлэх ба санал хураалтын үе 10 минутын турш үргэлжлэх болно. Та бүхэн саналын хуудсаа тус хугацаанд багтаан бөглөж танхимын хойд хэсэгт байрлах тооллогын комиссын гишүүдэд хүлээлгэж өгнө үү. Цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигч та бүхэн мөн саналаа хугацаандаа багтаан өгөхийг хүсье.

Санал хуудас бөглөх зааварчилгааны бичлэг. Саналын хуудас бөглөх гарын авлагатай танилцана уу. Та саналын хуудас бөглөхдөө дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд: Санал өгөх заавартай сайтар танилцах, Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл хэсгийг гаргацтай алдаагүй бөглөх, Саналын хуудсыг бөглөхдөө хэлэлцэх асуудлын ард талын саналын хувилбараас зөвхөн нэгийг сонгож харгалзах нүдэнд зөв тэмдэг эсвэл нэмэх тэмдгийн аль нэгийг тавина. Хувьцаа эзэмшигч та Хувь хүн бол хувьцаа эзэмшигч хувь хүн бөглөнө хэсэгт, хуулийн этгээдийг төлөөлөн оролцож байгаа бол хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бөглөнө хэсэгт мэдээллийг бөглөн гарын үсэг зурна. Санал өгсөн хувьцаа эзэмшигч танд баярлалаа.

Хөглөгч О.Баярсайхан:

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид аа. ХХБ-ны 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын санал хураалтын хугацаа дуусгавар болсон тул санал хураалтын дүн болон ХЭХ-ын шийдвэрүүдийн талаар танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Л.Одмаа таныг индэрт урьж байна

Тооллогын комиссын дарга Л.Одмаа:

Худалдаа, хөгжлийн банкны 2024 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурал 90.58% ирцтэйгээр хуралдаж хүчин төгөлдөр болсоныг тэмдэглээд, Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулья.

**“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон тооллогын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дахь заалт, 67.3.6 дахь заалт, 67.3.8 дахь заалт, 67.4 дэх хэсэг, 72 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.19 дахь хэсэг болон Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахимаар болон цаасаар ирүүлсэн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” асуудалд хурлаас гарах шийдвэр болон түүний төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон тооллогын дүнг доор дурдсанаар баталсугай.

Тооллогын дүн:

Зөвшөөрсөн 45836539 ширхэг хувьцаа буюу 99.99989 хувь;

Татгалзсан0..... ширхэг хувьцаа буюу0.00.... хувь;

Түдгэлзсэн0..... ширхэг хувьцаа буюу0.00.... хувь.

2. “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” асуудалд өгсөн саналыг тоолоход нийт 0 ширхэг хувьцаа буюу 0.00 хувьд эзлэх хүчингүй саналын хуудас байсныг дурдсугай.
3. Шийдвэрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан тооллогын дүнг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Л.Одмаа)-д үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Л.ОДМАА

**“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон тооллогын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дахь заалт, 67.3.6 дахь заалт, 67.3.8 дахь заалт, 67.4 дэх хэсэг, 72 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.19 дэх хэсэг болон Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахимаар болон цаасаар ирүүлсэн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай” асуудалд хурлаас гарах шийдвэр болон түүний төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон тооллогын дүнг доор дурдсанаар баталсугай.

Тооллогын дүн:

Зөвшөөрсөн 45836520 ширхэг хувьцаа буюу 99.99985 хувь;

Татгалзсан0..... ширхэг хувьцаа буюу ..0.00... хувь;

Түдгэлзсэн19.... ширхэг хувьцаа буюу 0.00004 хувь.

2. “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай” асуудалд өгсөн саналыг тоолоход нийт 0 ширхэг хувьцаа буюу 0.00 хувьд эзлэх хүчингүй саналын хуудас байсныг дурдсугай.

3. Шийдвэрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан тооллогын дүнг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Л.Одмаа)-д үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Л.ОДМАА

Хөтлөгч О.Баярсайхан:

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг албан ёсоор хаан үг хэлнэ үү хэмээн Хурлын дарга ноён Коппа таныг урьж байна.

Хурлын дарга Рандолф Коппа:

[АНГЛИ ХЭЛНЭЭС ОРЧУУЛАВ]

Худалдаа, хөгжлийн банкны нэрийн өмнөөс эрхэм хөрөнгө оруулагч та бүхнийг хүрэлцэн ирж саналаа өгсөнд талархлаа илэрхийлж байна. Тооллогын комиссын гишүүд, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг амжилттай зохион байгуулахад гар бие оролцсон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны хамт олон болон бусад ажилтнууддаа мөн талархал илэрхийлэе. Өнөөдрийн хурлаар

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт болон;
2. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ирэх жилийн зардлыг амжилттай баталлаа.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхэндээ хуралдаа хүрэлцэн ирж, идэвхитэй оролцсонд баярлалаа. Хурал өндөрлөж байгааг мэдэгдэж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.Зүрм

Н.НЯМСҮРЭН